



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 1/199

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах,
хаягийн өөрчлөлт хийх, хүчингүй болгох тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 10.1.5, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 35.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн 2019 оны 10 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын стандартын шаардлагын биелэлтийг хангаж спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох 10 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг 1 дүгээр, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын стандартын шаардлагын биелэлтийг хангаж сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох 2 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг 2 дугаар, улирлын түр үйлчилгээ үзүүлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын стандартын шаардлагыг хангаж спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг шинээр олгох 1 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг 3 дугаар, худалдааны газрын стандартын шаардлагын биелэлтийг хангаж спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг шинээр олгох 23 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын стандартын шаардлагын биелэлтийг хангаж спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгах 29 аж ахуйн нэгжийн нэрсийн жагсаалтыг 5 дугаар, худалдааны газрын стандартын шаардлагын биелэлтийг хангаж спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг сунгах 199 аж ахуйн нэгжийн жагсаалтыг 6 дугаар хавсралт, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын стандартын шаардлагыг хангаж спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгах 1

1110300578

1110300218